МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.10.02 № 68

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Г.ТЭМҮҮЛЭН ТАНАА

Хууль бус алт олборлолт, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой асуудлын тухай

Хууль сахиулах байгууллагын удирдах болон бусад алба хаагчид зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус алт олборлолт, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой байж болзошгүй гэх мэдээлэл нь зөвхөн тухайн алба хаагчдын асуудал бус, хууль сахиулах тогтолцооны хараат бус байдал, шударга ёс, иргэдийн итгэл үнэмшил, үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой ноцтой асуудал юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайд асан С.Амарсайханы олон нийтэд мэдэгдсэн мэдээллийн үнэн бодит байдлыг баримтаар тогтоосон, эсхүл шалгагдаж байгаа, шалгалтаар тогтоогдоогүй зэргээр ялгамжтай байдлаар төрийн эрх бүхий байгууллагаас бодитой, нэгдсэн мэдээлэл өгөх шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэн хууль бус алт олборлолт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, түүнчлэн эдгээр гэмт хэрэгт хууль сахиулах байгууллагын алба хаагчид, удирдах албан тушаалтан холбоотой байж болзошгүй талаар олон нийтэд мэдээлэгдсэн асуудлыг шалган шийдвэрлэж байгаа нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар энэхүү асуулгыг тавьж байна.

**Хууль бус алт олборлолттой холбоотой асуудлын талаар**

1.2021–2026 онд хууль бус алт олборлолт болон ашигт малтмалын хууль бус олборлолттой холбоотой бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо, тэдгээрээс прокурорт шилжүүлсэн, хэрэгсэхгүй болгосон, шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэргийн тоо, учирсан болон нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээний талаарх тоон мэдээллийг жил тус бүрээр;

2.Хууль зүй, дотоод хэргийн сайд асан С.Амарсайхан хууль бус алт олборлолттой холбоотойгоор Цагдаагийн ерөнхий газар болон бусад байгууллагад өгсөн гэх үүрэг, чиглэл, шилжүүлсэн баримт, мэдээлэл тус бүрийг шалгасан эсэх;

**Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой асуудлын талаар**

3.Монгол Улсад 2021–2026 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо, хураан авсан бодисын төрөл, хэмжээ,

2026000200

хэрэглэгчдийн насны бүлэг, хүйсийн харьцаа, мөн хил дамнасан шинжтэй эсэх талаарх тоон мэдээллийг жил тус бүрээр;

**Хууль бус үйл ажиллагаанд хууль сахиулах байгууллага, төрийн албан тушаалтан болон бусад этгээдийн оролцоо, дотоод хяналт, хариуцлагын талаар**

4.Экологийн цагдаагийн албаны дарга асан, цагдаагийн хурандаа Б.Оюутболд болон хууль сахиулах байгууллагын бусад алба хаагчид хууль бус алт олборлолт, уул уурхайн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлсөн, хамгаалсан, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой байж болзошгүй гэх мэдээллийг шалгаж байгаа байгууллага, шалгалтын явцын талаар;

5.Цагдаа болон бусад хууль сахиулах байгууллагын алба хаагчид хууль бус алт олборлолт, мансууруулах бодисын хууль бус эргэлт, түүнийг зохион байгуулахад оролцсон, хамгаалсан, эсхүл эдгээр гэмт хэргийг шалгах, мөрдөн шалгах ажиллагаанд хууль бусаар нөлөөлсөн гэх асуудлаар 2024–2026 онд хийсэн дотоод хяналт шалгалтын тоо, шалгалтаар тогтоогдсон зөрчил, хэрэгт холбогдсон алба хаагчдын тоо, тэдгээрт оногдуулсан сахилгын, зөрчлийн болон эрүүгийн хариуцлагын талаарх тоон мэдээлэл;

6.Хууль бус алт олборлолт, мансууруулах бодисын хууль бус эргэлтэд улс төр, бизнесийн нөлөө бүхий этгээд, төрийн болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд зэрэг зохион байгуулалттай сүлжээ байдаг эсэх талаарх мэдээлэл;

7.Хууль зүй, дотоод хэргийн сайд асан С.Амарсайханы "цагдаагийн байгууллага дотроос хэргийг мөрдөхгүй байх, зогсоох, хаах чиглэл өгсөн" гэх агуулгатай олон нийтэд хийсэн мэдэгдлийг албан ёсоор шалгасан эсэх, шалгалтын явц, үр дүн;

8.Хууль сахиулах байгууллагын алба хаагч гэмт хэрэгт оролцох, мөрдөн шалгах ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх эрсдэлийг бууруулах, дотоод хяналтын хараат бус байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөндлөнгийн болон прокурорын хяналтыг бэхжүүлэх чиглэлээр хийхээр төлөвлөж байгаа ажил, эрх зүйн болон институцийн өөрчлөлт хийх шаардлагатай эсэх, цаашид баримтлах бодлогын талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ЭРДЭНЭБОЛД

2026000200